



## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**2021 ОНЫ ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

**2021 он**

*Дэлгэрэнгүйжүүлэв  
Чадлыг дэлгэрэнгүүлэв*

## **1. 2021 онд гүйцэтгэсэн ажил**

2021 онд Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу 7, төлөвлөгөөт бус 7, нийт 14 дотоод аудит, хяналт шалгалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

### ***1.1 Төлөвлөгөөт ажил***

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны баталсан төлөвлөгөөний дагуу 7 дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- I. Эрчим хүчиний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 21/01 дугаар удирдамжийн дагуу 2020 оны жилийн эцсийн Эрчим хүчиний салбарын харьяа байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, 6 зөвлөмжийг гаргасан.
- II. Эрчим хүчиний сайдын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн A/77 дугаар тушаалаар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж гүйцэтгэв. Аудитаар 5 асуудлын хүрээнд 8 зөвлөмжийг хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллав.
- III. Эрчим хүчиний сайдын 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн A/90 дүгээр тушаалаар “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХХК-ийн 2020 оны санхүү, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэв. Аудитаар 8 үл нийцлийг илрүүлэн 9 зөвлөмжийг хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллав.
- IV. Эрчим хүчиний сайдын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн A/107 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй, нийслэлд ажиллаж байгаа 68 ширхэг халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох /Багц-9/ (XVII.1.33) ажил”-д дотоод аудитыг хийж гүйцэтгэв. Дотоод аудитын хорооны 2021.06.19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн аудитын дүн, зөвлөмжийг 09, 10 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Зөвлөмжийн биелэлтийг 2021.12.30-ны өдрийн дотор ирүүлэх үүрэг даалгаврыг 2021.06.29-ний өдрийн в/2294 албан тоотоор ЭХХТ ТӨҮГ-т хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллав.
- V. Эрчим хүчиний сайдын 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн A/141 тоот тушаалын дагуу 2021 оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж, дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг хангах үүрэг даалгавар бүхий 2021.09.09-ны өдрийн в/3189 тоот албан бичгийг салбарын нийт 46 байгууллагад хүргүүлсэн. Биелэлтэд хяналт тавин ажиллав.
- VI. Эрчим хүчиний сайдын 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн A/207 тушаалын дагуу “Таван толгойн дулааны цахилгаан станц” ТӨХХК-д үйл ажиллагаанд дотоод аудит хийв. 2021.11.11-ний өдрийн а/4045 албан тоотоор аудитын тайлан болон зөвлөмжийн хэрэгжүүлэх үүрэг даалгаварыг “Таван толгойн дулааны цахилгаан станц” ТӨХХК-д хүргүүлэв.
- VII. Сайдын 2021.11.11-ний өдрийн A/229 тушаалын дагуу Сайдын багцын 2021 оны улсын төсвөөс санхүүжигдсэн худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэв.

### ***1.2 Төлөвлөгөөт бус аудит, хяналт шалгалт***

Төлөвлөгөөт бус 7 ажил хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- I. Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр баталсан удирдамжийн дагуу “Багануурын дулааны станц” ТӨХК-д хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн Сайдын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн a/853 албан бичгээр “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг даалгавар хүргүүлэв.
- II. Сайдын 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн A/52 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэж буй сайжруулсан шахмал түлшний технологийн үйл ажиллагаа, орц норм, техникийн стандартын шаардлагад нийцэж буй байдалд хяналт шалгалт хийв.
- III. Сайдын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн A/151 тушаалын дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын ажлын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиллав.
- IV. Сайдын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн A/153 тушаалаар Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн нэгжийн үйл ажиллагаанд аудит хийж гүйцэтгэв. Зөвлөмжийн биелэлтийг 2021.12.25-ны өдрийн дотор тайлagnah үүрэг даалгаврыг 2021.11.03-ны өдрийн в/3956 тоот албан бичгээр төслийн нэгжид хүргүүлж, биелэлтийг хянаж ажиллав.
- V. Сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн A/160 тушаалаар цахилгаан түгээх сүлжээ компаниудын мөнгөн урсгалд хийх хяналт шалгалтыг гүйцэтгэв.
- VI. Сайдын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн A/219 дүгээр тушаалын дагуу цахилгаан, дулаан түгээх сүлжээний 5 компани /ДСЦТС, ДДС, БХЭХҮЧ ХХК, Хөвсгөл ЭХ ХХК, БӨЦШСГ/-ийн мөнгөн урсгалд хяналт шалгалт хийв.

Шалгалтанд хамрагдсан компаниудын хувьд дотоод аудитын явцад давхардсан тоогоор 52 үл нийцэл бүхий асуудал илэрсэн бөгөөд алдааг дахин гаргахгүй, цаашид анхаарч ажиллах талаар 73 зөвлөмжийг хүрүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг Дотоод аудитын хорооны тогтоол болон тайлангийн хамт албан бичгээр хүргүүлж ажиллав.

*Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж:*

Үндэсний аудитын газраас хийсэн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2021.06.25-ны өдөр тайлagnah үүрэг даалгаврыг 2021.04.09-ний өдрийн в/1262 тоот албан бичгээр салбарын үйлдвэр, компаниудад хүргүүлэв. Биелэлтийг хүлээн авч үнэлэн 84.5 хувийн хэрэгжилттэй байгааг үнэлэн хэрэгжилт дутуу зөвлөмж, акт, албан шаардлагыг 2022.01.20-ны өдрийн дотор эргэн тайлagnahыг 2021.07.22-ны өдрийн a/2536 албан тоотоор хүргүүлэв.

### 3.5 Бусад мэдээлэл

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайлан, танилцуулга, зөвлөмж бусад нотлох баримтуудын хуулбарыг Дотоод аудитын стандартын дагуу ажлын баримтуудын бүрдэл болгож тайланд хавсаргаж архивын хуулийн дагуу эмхэлж цэгцлэн архивт хүлээлгэн өгсөн.

Яамны цахим хуудсанд 2021 оны дотоод аудитын төлөвлөгөө, 2020 оны дотоод аудитын тайланг байршуулж ажилласан.

#### 4 Дүгнэлт

- 2021 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх “Дотоод аудитын хороо”-гоор батлуулсан Дотоод аудитын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг гүйцэтгэж, зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийг эргэж хянан хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлэв.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж хүргүүлж, хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллав.
- Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайландаа хийсэн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин, биелэлтийг хангуулахаар үүрэг даалгавар хүргүүлэн ажиллав.

#### ДОТООД АУДИТЫН 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ буюу төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	Төрийн өмчийт хувьцаат компани, төрийн өмчийт үйлдвэрийн газруудын 2020 оны үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх: <ul style="list-style-type: none"> <li>- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК,</li> <li>- “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”</li> <li>- 68 ширхэг халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох /Багц-9/ ажил</li> <li>- “Таван толгойн дулааны цахилгаан станц” ТӨХХК</li> <li>- Сайдын багцын 2021 оны ХАА</li> </ul>	биелсэн	100%
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд: <ul style="list-style-type: none"> <li>- 2020 оны жилийн эцсийн байдлаар /2021.01.31/</li> <li>- 2021 оны эхний хагас жилийн байдлаар /2021.08.31/</li> </ul>	биелсэн	100%
Төлөвлөгөөт бус ажил:			
3	<ul style="list-style-type: none"> <li>- “Багануурын дулааны станц” ТӨХК</li> <li>- “Таван толгой түлш” ТӨХХК</li> <li>- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК</li> <li>- “Эрдэнэбүрэнгийн УЦС” төслийн нэгж</li> <li>- Цахилгаан түгээх сүлжээ компани</li> <li>- Дулаан, цахилгаан түгээх сүлжээний 5 компани</li> </ul>	биелсэн	100%

Дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсан 2021 оны жилийн ажил үйлчилгээг **100%** хийж гүйцэтгэсэн.

---оо---